
ЗЭЭЛИЙН ДУГААР _____ - MON (SEFF-FA)

МОНГОЛ УЛС

болон

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

хоорондын

ХӨТӨЛБӨРИЙН ХЭЛЭЛЦЭЭР
(Энгийн үйл ажиллагаа)

ОГНОО _____

MON 55291

Монгол Улсын Ерөнхий сайдын
АЛБАН ТӨСНИ ОРЧУУЛИГ АМ

Гарын үсэг /Signature/ *01*.....

2022 оны 01 сарын 12 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
ТӨСНИ ОРЧУУЛИГ АМ

ХӨТӨЛБӨРИЙН ХЭЛЭЛЦЭЭР (Энгийн үйл ажиллагаа)

МОНГОЛ УЛС (“Зээлдэгч” гэх) болон АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (“АХБ” гэх) хооронд _____-ны өдөр байгуулсан ХЭЛЭЛЦЭЭР.

(А) Зээлдэгч нь АХБ-ны жижиг зардлыг санхүүжүүлэх хөтөлбөр (“Хөтөлбөр” гэх)-ийн хүрээнд зөвшөөрөгдсөн жижиг хэмжээний үйл ажиллагаа (цаашид дангаар нь “Үйл ажиллагаа”, хамтад нь “Үйл ажиллагаанууд” гэх)-г санхүүжүүлэх зорилгоор АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэрээс үйл ажиллагааны дэд зээл эсвэл үйл ажиллагааны дэд зээлүүд (цаашид дангаар нь “Үйл ажиллагааны дэд зээл”, хамтад нь “Үйл ажиллагааны дэд зээлүүд” гэх) авах хүсэлтийг АХБ-инд үе үе гаргаж болно; мөн

(В) Зээлдэгч үйл ажиллагааны дэд зээл авах хүсэлтийг гаргаж болох бүтэц, АХБ-наас уг хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны дэд зээл олгоход тавих ерөнхий нөхцөл, болзлыг тогтоохыг Зээлдэгч болон АХБ хамтдаа хүсэж буй;


ИЙМЭЭС талууд дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ


Нэр томъёоны тодорхойлолт

Заалт 1.01. Энэхүү хэлэлцээрт ашигласан нэр томъёо дараах утгыг илэрхийлнэ. Үүнд:

- (a) “ҮАХГА” гэж Зээлдэгч болон АХБ харилцан тохиролцсон хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан үйл ажиллагаа хэрэгжүүлэх гарын авлага нэг бүр, Зээлдэгч болон АХБ-ны холбогдох захиргааны журмын дагуу оруулсан нэмэлт өөрчлөлтийн хамт;
- (b) “Үйл ажиллагааг гүйцэтгэгч байгууллага” гэж үйл ажиллагааны дэд зээлийн гэрээнд заасан, үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллага, агентлагийг;
- (c) “Үйл ажиллагааны дэд зээлийн данс” гэж үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгийг хийсэн эсхүл хийхээр АХБ-наас өөрийн дотоод данс, бүртгэлд Зээлдэгчийн нэр дээр нээсэн буюу нээх дансыг;
- (d) “Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ” гэж Зээлдэгч болон АХБ-ны хооронд үндсэндээ энэхүү Хэлэлцээрийн 3-р хуваарьт заасан маягтын дагуу байгуулах захидал гэрээг;
- (e) “Үйл ажиллагааны дэд зээлийн хүчин төгөлдөр болсон өдөр” гэж Зээлдэгч гарын үсэг зурж баталгаажуулсан үйл ажиллагааны дэд зээлийн гэрээг АХБ хүлээн авч гарын үсэг зурсан өдрийг;



- (f) “Үйл ажиллагааны дэд зээлийн хугацаа” гэж үйл ажиллагааны дэд зээл хүчин төгөлдөр болсон өдрөөс хойших 5 жилийн хугацааг;
- (g) “Үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлт” гэж Зээлдэгч энэхүү Хэлэлцээрийн 2-р хуваарьт заасан маягтын дагуу бөглөж АХБ-инд хүргүүлсэн мэдэгдлийг;
- (h) “Хөтөлбөрийн боломжит дүн” гэж аль ч үед Хөтөлбөрийн нийт дүнг (энэхүү Хэлэлцээрийн 2.01 заалтад заасны дагуу)-ээс тухайн хөтөлбөрийн хүрээнд үлдсэн үйл ажиллагааны дэд зээлүүдийн нийт цэвэр үлдэгдэл дүнг;
- (i) “ам.доллар” буюу “\$” гэж Америкийн Нэгдсэн Улсын хууль ёсны мөнгөн тэмдэгтийг;
- (j) “Хүчин төгөлдөр болох өдөр” гэж энэхүү Хэлэлцээрийн 5.02 заалтад заасны дагуу энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болж, үйлчилж эхлэх өдрийг;
- (k) “Дараагийн зээл” гэж дараачийн төслийг ямар нэг зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлэх зорилгоор АХБ-наас олгох зээлийг;
- (l) “Дараагийн зээлийн хэлэлцээр” гэж дараагийн зээлд зориулж Зээлдэгч болон АХБ-ны хооронд байгуулж, АХБ-ны үйл ажиллагааны дэд зээлийг дахин санхүүжүүлэхээр тусгасан зээлийн хэлэлцээрийг;
- (m) “Дараагийн төсөл(үүд)” гэж АХБ-наас санхүүжүүлэхээр төлөвлөж буй төсөл(үүд)-ийг;
- (n) “Хэрэгжиж буй зээлийн хэлэлцээр” гэж АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй төсөлд зориулан Зээлдэгч болон АХБ хооронд байгуулсан байгаа бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулснаар үйл ажиллагааны дэд зээлийг дахин санхүүжүүлэх зээлийн хэлэлцээрийг;
- (o) “Хөтөлбөрийн ашиглалтын хугацаа” гэж энэхүү Хэлэлцээрийн 2.02 заалтад заасан хөтөлбөрийн ашиглах хугацааг;
- (p) “Ерөнхий нөхцөл” гэж энэхүү хэлэлцээрийн 1-р хуваарьт заасан үйл ажиллагааны дэд зээлд хамаарах ерөнхий нөхцөлийг;
- (q) “ЖЗСХ” гэж жижиг зардлыг санхүүжүүлэх хөтөлбөрийг; мөн
- (r) “Хөтөлбөрийн нийт дүн” гэж энэхүү Хэлэлцээрийн 2.01 заалтад заасан хөтөлбөрийн нийт дүнг хэлнэ.



ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хөтөлбөр

Заалт 2.01. АХБ-ны санхүүжилтээр төслүүдийг бэлтгэж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Үйл ажиллагааг санхүүжүүлэх хөтөлбөрийг АХБ-наас үүгээр Зээлдэгчид олгож байна. Энэхүү санхүүжилтийг АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлэх бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд авах боломжтой санхүүжилтийн дээд хэмжээ нь хорин сая ам.доллар (20,000,000 ам.доллар) болно.

Заалт 2.02. (a) Энэхүү Хэлэлцээрийн дагуу АХБ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 жилийн хугацаанд Үйл ажиллагаануудыг санхүүжүүлэх зорилгоор Үйл ажиллагааны дэд зээлүүдийг Зээлдэгчид олгож болно.

(b) Хөтөлбөрийн ашиглалтын хугацаа дуусахад АХБ Зээлдэгчтэй зөвшилцсөний үндсэн дээр уг хөтөлбөрийн ашиглалтын хугацааг 5 жилээр нэмж сунгаж болно.

Заалт 2.03. (a) Зээлдэгч нь АХБ-нд зээлийн нийт дүнгийн 0.15%-тай тэнцэх хэмжээний урьдчилгаа хураамжийг дараах өдрөөс өмнө төлнө, үүнд: (i) хүчин төгөлдөр болох өдөр; эсвэл (ii) энэхүү хэлэлцээр байгуулагдсан өдрөөс хойш 60 хоногийн дараа.

(b) Энэхүү Хэлэлцээрийн 2.02(b) заалтад заасны дагуу Хөтөлбөрийн ашиглалтын хугацааг сунгасан тохиолдолд Зээлдэгч сунгах үед нийт Хөтөлбөрийн үнийн дүнгийн 0.15%-тай тэнцэх урьдчилгаа хураамжийг АХБ-инд төлнө.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ


Үйл ажиллагааны дэд зээл

Заалт 3.01. (a) Зээлдэгч нь энэхүү Хэлэлцээрийн 2-р хуваарьт заасан маягтын дагуу зохих ёсоор бөглөсөн Үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлтийг АХБ-инд ирүүлснээр уг Хөтөлбөрийг ашиглаж болно.

(b) АХБ нь Үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлттэй холбогдуулан ирүүлсэн баримт бичиг, материалыг худалдан авалт, санхүүгийн удирдлага, зарцуулалт, байгаль орчин, нийгмийн хамгаалал зэрэг АХБ-ны холбогдох үйл ажиллагааны бодлого, журмын дагуу хянан үзэж, хүлээн авсны үндсэн дээр Үйл ажиллагааны дэд зээлийг тус бүрийг олгоно.

Заалт 3.02. (a) АХБ-наас олгосон Үйл ажиллагааны дэд зээл нэг бүр нь (i) энэхүү Хэлэлцээр; (ii) Ерөнхий нөхцөл, болзол; мөн (iii) энэхүү Хэлэлцээрийн 3-р хуваарьт заасан маягтын дагуу Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээнд заасан тодорхой нөхцөлүүдтэй нийцсэн байна.

(b) Энэхүү Хэлэлцээрийг байгуулснаар, мөн аль нэг Үйл ажиллагааны дэд зээл олгосноор Зээлдэгчид дараагийн төсөлд санхүүгийн туслалцаа заавал үзүүлэх үүрэг амлалт, хуулийн үүрэг, хариуцлага АХБ хүлээхгүй.



Заалт 3.03. Үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлтийг АХБ зөвшөөрсний дараа Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээг АХБ-наас Зээлдэгчээр гарын үсэг зуруулахаар хүргүүлнэ. Үйл ажиллагааны дэд зээл нь Зээлдэгч гарын үсэг зурсан Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээг АХБ хүлээн авсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

Заалт 3.04. Ерөнхий нөхцөл, болзлын 2.03 заалтад заасны дагуу эргэн төлөгдсөн, эсхүл дахин санхүүжүүлсэн Хөтөлбөрийн аль нэг хэсэг (Үйл ажиллагааны дэд зээл хэлбэрээр санхүүжүүлсэн)-ийг шинэ Үйл ажиллагааны дэд зээл(үүд)-эд ашиглаж болохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ


Тусгай нөхцөл

Заалт 4.01. Зээлдэгч нь Үйл ажиллагаа нэг бүрийг холбогдох ҮАХГА-д заасан нарийвчилсан зохицуулалтын дагуу хэрэгжүүлэхийг баталгаажуулна. Зээлдэгч болон АХБ харилцан зөвшөөрсний дараа холбогдох ҮАХГА-д оруулсан аливаа дараагийн өөрчлөлт хүчин төгөлдөр болно. ҮАХГА болон холбогдох Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээний хооронд ялгаатай байдал гарсан тохиолдолд Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээний заалтыг баримтална.

Заалт 4.02. (a) Зээлдэгч нь Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан (i) Үйл ажиллагаа нэг бүрийн зорилгоор тусдаа данс нээж, бүртгэл хөтлөх эсхүл тийнхүү нээж, хөтлөх нөхцөлөөр хангах; (ii) АХБ-наас хүлээн зөвшөөрсөн санхүүгийн тайлан бэлтгэх стандартын дагуу Үйл ажиллагаа нэг бүрийн санхүүгийн тайланг жил бүр гаргах; (iii) уг санхүүгийн тайланд олон улсын аудитын стандартын дагуу эсхүл түүнтэй дүйцэх АХБ-наас хүлээн зөвшөөрөхүйц дотоодын аудитын стандартын дагуу, мэргэжлийн ур чадвар, туршлага болон ажлын даалгаврын хувьд АХБ-ны шаардлагыг хангах хөндлөнгийн, бие даасан аудитын байгууллагаар жил бүр аудит хийлгэх; (iv) эдгээр аудит нэг бүрийн хүрээнд санхүүгийн тайлан, Үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгийн зарцуулалтын талаарх аудиторын дүгнэлт болон аудитын шалгалтын үеэр Үйл ажиллагаа нэр бүрийн дотоод хяналтын талаар ямар нэг дутагдал илэрсэн бол түүнийг дурдсан менежментийн захидлыг хамарсан аудитын тайланг аудитораар бэлтгүүлэх; мөн (v) тухайн санхүүгийн жил дууссанаас хойш 6 сарын дотор аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын тайлан болон менежментийн захидлын хувийг англи хэл дээр бэлтгэж, АХБ-нд хүргүүлэх бөгөөд АХБ-ны хүсэлтээр эдгээр баримт бичиг, аудитын шалгалттай холбоотой бусад мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгнө.

(b) АХБ нь Үйл ажиллагаануудын аудит хийсэн санхүүгийн жилийн тайлан болон уг тайлангийн талаарх аудиторуудын дүгнэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор өөрийн цахим хуудаснаа байршуулна.

(c) АХБ нь Үйл ажиллагаануудын санхүүгийн тайлан, тэдгээртэй холбоотой санхүүгийн асуудлыг дээрх дэд хэсэг (a)(iii)-ын дагуу томилогдсон аудиторуудтай хэлэлцэх хүсэлтийг тавьсан тохиолдолд Зээлдэгч энэхүү боломжоор хангаж, АХБ-наас хүсэмжилсэн ийм хэлэлцээний үед аудиторуудын төлөөлөгчдөд эрх олгож, байлцуулах арга хэмжээ авна. Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллага өөрөөр тохирсноос бусад тохиолдолд хэлэлцээний үед Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллагын эрх бүхий төлөөлөгч заавал байлцана.



Заалт 4.03. (а) Зээлдэгч, Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллага болон хэрэгжүүлэгч байгууллага нь (i) АХБ-ны Авилгатай тэмцэх бодлогыг (1998 он, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт) даган мөрдөх бөгөөд авилга авсан, залилан мэхэлсэн, үгсэн тохиролцсон, албадлагын шинжтэй байж болзошгүй Үйл ажиллагаатай холбогдон гарсан аливаа үйлдлийг АХБ шууд буюу төлөөлөгчөөрөө дамжуулан мөрдөн шалгалт явуулах эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн; мөн (ii) тухайн мөрдөн шалгалтын ажиллагаатай хамтран ажиллаж, мөрдөн шалгалтын ажиллагааг хангалттай дуусгахад шаардлагатай бүх тусламжийг үзүүлнэ.

(b) Зээлдэгч, Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллага болон хэрэгжүүлэгч байгууллагууд нь АХБ-нд хүлээн зөвшөөрөгдсөн авилгатай тэмцэх заалтууд, тэр дундаа Үйл ажиллагаатай холбоотой бүх гэрээлэгч, ханган нийлүүлэгч, зөвлөх болон бусад үйлчилгээ үзүүлэгч этгээдийн данс, бүртгэлд аудит хийх, шалгах АХБ-ны эрхийг тодорхойлсон заалтуудыг тендерийн бүх баримт бичиг, гэрээнд тусгаж, баталгаажуулна.

ТАВДУГААР ЗҮЙЛ

Хүчин төгөлдөр болох; цуцлах


Заалт 5.01. (а) Энэхүү Хэлэлцээрийг Зээлдэгчийн нэрийн өмнөөс үйлдэж, хүргүүлэх нь зохих ёсоор зөвшөөрөгдсөн, эсхүл шаардлагатай бүх байгууллага, засгийн газрын алхмыг авч хэрэгжүүлэн соёрхон баталсан гэдгийг АХБ-ны шаардлагад нийцсэн нотлох баримтыг АХБ хүлээн авснаар энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

(b) Дээрх 5.01(а) заалтад заасны дагуу гаргаж өгөх нотлох баримтын хүрээнд Зээлдэгч нь (i) энэхүү Хэлэлцээрийг зохих ёсоор үйлдсэн болохыг АХБ-наас хүлээн зөвшөөрөгдөх этгээдээс гаргасан АХБ-ны шаардлагад нийцсэн хууль зүйн дүгнэлтийг тус банканд гаргаж өгөх буюу гаргаж өгөх ёстой нөхцөлөөр хангах бөгөөд тус хууль зүйн дүгнэлтэд (i) зохих зөвшөөрлийн дагуу энэхүү Хэлэлцээрийг соёрхон баталж, Зээлдэгчийн нэрийн өмнөөс үйлдэж, хүргүүлсэн; мөн (ii) энэхүү Хэлэлцээр болон түүний хүрээнд Зээлдэгчийн нэрийн өмнөөс байгуулах Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ тус бүр нь тэдгээрт заасан нөхцөлийн дагуу Зээлдэгч хууль ёсоор заавал биелүүлэх үүрэгтэй болохыг дүгнэсэн байна.

Заалт 5.02. АХБ болон Зээлдэгч өөрөөр тохиролцоогүй тохиолдолд энэхүү Хэлэлцээр нь 5.01 заалтад заасан нотлох баримтыг хүлээн авч зөвшөөрснөө АХБ Зээлдэгчид мэдэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Заалт 5.03. (а) Хэрэв хэлэлцээр байгуулагдсан өдрөөс хойш 90 хоногийн дотор энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болж, үйлчилж эхлэх боломжгүй бол АХБ хойшилсон шалтгааныг судалж, өөр нэг өдрөөр тогтоосноос бусад тохиолдолд энэхүү Хэлэлцээр болон талуудын бүх үүрэг цуцлагдаж, дуусгавар болно.

(b) 5.03(а) заалтад заасны дагуу Хэлэлцээрийг цуцалсны дараа АХБ нь хөтөлбөрийн нийт үнийн дүнгийн 0.15%-тай тэнцэх урьдчилгаа хураамжийг буцаан олгоно.



ЗУРГААДУГААР ЗҮЙЛ

Үүргийн гүйцэтгэл хангуулах ба эрхээ хэрэгжүүлэхгүй байх

Заалт 6.01. (a) Энэхүү Хэлэлцээрт заасан АХБ болон Зээлдэгч талын эрх, үүрэг нь аль ч улсын хууль тогтоомж, улс төрийн болон орон нутгийн засаг захиргааны хууль тогтоомжоос үл хамааран зөвхөн түүнд заасан нөхцөлийн дагуу хүчин төгөлдөр үйлчилж, үүргийн гүйцэтгэл хангуулна.

(b) АХБ болон Зээлдэгчийн аль нь ч энэхүү заалтын хүрээнд явагдах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Азийн Хөгжлийн Банкнийг үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийн аль нэг заалт болон бусад шалтгааныг иш татан энэхүү Хэлэлцээрийн аль нэг заалт хүчин төгөлдөр бус, үүргийн гүйцэтгэл хангах боломжгүй гэх нэхэмжлэл гаргах эрхгүй.

Заалт 6.02. Аливаа гэрээний зөрчил гарахад хэлэлцээрийн аль нэг тал энэхүү хэлэлцээрээр өөрт олгогдсон аливаа эрх, эрх мэдлийг эдлэлгүй өнгөрөөсөн, эдлэхийг хойшлуулсан эсхүл зөрчилтэй холбоотойгоор эрхээ сэргээлгээгүй явах нь тухайн эрх, эрх мэдлийг эдлэх болон эрхээ сэргээлгэх боломжид хязгаарлалт болохгүй, эсхүл эдгээр эрхээс татгалзсан буюу зөрчлийг хүлээн зөвшөөрсөн хэмээн үл тооцно. Мөн тухайн гэрээний зөрчил гарахад аль нэг тал тийнхүү өнгөрөөх нь бусад буюу дараачийн зөрчил гарахад хэлэлцээрт олгогдсон эрх, эрх мэдлээ эдлэх эсхүл эрхээ сэргээлгэхэд нөлөөлөхгүй буюу хязгаарлалт болохгүй.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

Бусад


Заалт 7.01. Энэхүү Хэлэлцээрийн Хөтөлбөр болон Үйл ажиллагааны дэд зээл нэг бүрийн зорилгоор Зээлдэгч талын төлөөлөгч нь Зээлдэгчийн Сангийн сайд байна.

Заалт 7.02. Энэхүү Хэлэлцээрийн дагуу хүргүүлэхээр зөвшөөрөгдсөн болоод шаардлагатай аливаа мэдэгдэл, хүсэлтийг бичгээр үйлдэх бөгөөд биечлэн болон шуудан, факс, цахим шуудангаар илгээгч талаас хүлээн авагч талд хүлээлгэн өгөх бөгөөд ингэхдээ 7.03 заалтад заасан хүлээн авагч талын хаяг эсхүл тийнхүү мэдэгдэл, хүсэлт хүргүүлэхэд зориулан албан ёсоор дахин өөрчилж, мэдэгдсэн хаягийг ашиглана.

Заалт 7.03. Энэхүү Хэлэлцээрийн дагуу хүргүүлэхээр зөвшөөрөгдсөн болоод шаардлагатай аливаа хүсэлт, мэдэгдлийг доор заасан хаягаар явуулна.

Зээлдэгчийн хувьд

Сангийн яам
С.Данзангийн гудамж 5/1
Засгийн газрын 2-р байр
Улаанбаатар - 15160
Монгол Улс




Факс: (976-11) 320-247

АХБ-ны хувьд

Азийн Хөгжлийн Банк
Азийн Хөгжлийн Банкны өргөн чөлөө 6
Мандалуйонг хот
1550 Метро Манила
Филиппин Улс

Факс: (632) 8636-2444
(632) 8636-2302.




ЭНД ӨГҮҮЛСНИЙГ НОТЛОН, талууд зохих ёсоор эрх олгогдсон төлөөлөгчдөөрөө дамжуулан хэлэлцээрийн эхэнд дурдсан өдөр энэхүү Зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурж, АХБ-ны Төв байранд хүргүүлнэ.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

[Нэр, албан тушаал]

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ

[Нэр, албан тушаал]



ХӨТӨЛБӨРИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХУВААРЬ 1

Үйл ажиллагааны дэд зээлд хамаарах ерөнхий нөхцөл

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Зээлийн журам ба нэр томъёоны тодорхойлолт

Заалт 1.01. АХБ-ны 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн Энгийн нөхцөл бүхий зээлийн журам ("Зээлийн журам" гэх)-ын бүх заалт доор дурдсан өөрчлөлтөөс бусад тохиолдолд энэхүү Зээлийн хэлэлцээрт бүрнээ тусгагдсаны нэгэн адил хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Үүнд.

- (a) Зээлийн журамд дангаар тодорхойлсон буюу аль нэг тодорхойлолтын хүрээнд "Зээл" гэж заасан нэр томъёог "Үйл ажиллагааны дэд зээл" гэсэн нэр томъёогоор орлуулж хэрэглэнэ.
- (b) Зээлийн журамд дангаар тодорхойлсон буюу аль нэг тодорхойлолтын хүрээнд "Төсөл" гэж заасан нэр томъёог "Үйл ажиллагаа" гэсэн нэр томъёогоор орлуулж хэрэглэнэ.
- (c) Зээлийн журмын 2.01 (Тодорхойлолт)-д тодорхойлсон "Төслийн гэрээ" гэсэн нэр томъёог хасаж хэрэглэнэ.
- (d) Зээлийн журмын 2.01 (Тодорхойлолт)-д тодорхойлсон дараах нэр томъёог хасаж, оронд нь дараах нэр томъёог оруулан хэрэглэнэ. Үүнд:


"Хүчин төгөлдөр болох өдөр" гэж 10.01 заалтад заасны дагуу Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ, мөн хамааралтай бол Батлан даалтын гэрээ хүчин төгөлдөр болж, үйлчилж эхэлсэн өдрийг хэлнэ;

- (e) 2.01 (xx) хэсгийг хасаж, дараах утгаар орлуулан хэрэглэнэ:

"Суурь хүүгийн түвшин" гэж (i) евро, LIBOR-оос бусад зээлийн валют болон евро, Euribor-т хамаарах Заалт 3.02(c)-гийн дагуу АХБ-наас шийдвэрлэсэн хүүгийн түвшин; мөн (ii) АХБ-наас Заалт 3.02(c)-гийн дагуу шийдвэрлэж, Зээлдэгч болон Батлан даагчид түргэн шуурхай мэдэгдэх бусад суурь хүү болон холбогдох нэмэлт хүүгийн түвшнийг хэлнэ.

- (c) Заалт 3.02(b)-тэй залгуулаад доор тусгасан шинэ заалт 3.02(c)-г нэмж хэрэглэнэ:

Заалт 3.02 (c). Зээлийн аливаа дүнд LIBOR эсхүл Euribor-т суурилсан хүүг тооцох бөгөөд АХБ-наас (i) тухайн суурь хүүгийн түвшнийг холбогдох зээлийн валютад бүр мөсөн ашиглахаа болих, эсхүл тухайн суурь хүүг нийтэд зарладаг зохицуулагч байгууллагаас гаргасан мэдээлэл эсхүл мэдэгдэл нь бодитой бус



гэж үзэх эсхүл (ii) тус банк ийм суурь хүүгийн түвшнийг өөрийн актив, өр төлбөрийн удирдлагад хэрэглэх чадваргүй, эсхүл арилжааны хувьд хэрэглэх боломжгүй болсон гэж үзэх тохиолдолд АХБ нь холбогдох зээлийн валютад зохистой гэж үзсэн өөр суурь хүүгийн түвшин хэрэглэх болно. АХБ нь Зээлдэгч болон Батлан даагчид тухайн суурь хүү болон нэмэлт хүүгийн түвшин, тэдгээрийг хэрэглэхэд шаардлагатай Зээлийн хэлэлцээрийн холбогдох заалтын нэмэлт өөрчлөлтийн талаар нэн даруй мэдэгдэж, тийнхүү мэдэгдсэн даруй тухайн нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болно.


- (g) Заалт 10.01 (Хүчин төгөлдөр болоход урьдчилсан нөхцөл) хасаж, дараах утгаар орлуулан хэрэглэнэ:

“Заалт 10.01. Үйл ажиллагааны дэд зээл хүчин төгөлдөр болсон өдөр. (a) АХБ болон Зээлдэгч өөрөөр тохиролцоогүй тохиолдолд Зээлдэгч ба АХБ зохих ёсоор гарын үсэг зурсан Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ, мөн хамааралтай бол Батлан даалтын гэрээг АХБ хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, үйлчилж эхэлнэ;

(b) Хэрэв Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ хүчин төгөлдөр болсон байсан ч Үйл ажиллагааны дэд зээлийн данснаас Зээлдэгч мөнгөн хөрөнгө авах эрхийг АХБ түдгэлзүүлэх эрхтэй болох нөхцөл үүсэх тохиолдсон бол АХБ нь энэхүү заалтын (a)-д дурдсан хүчин төгөлдөр болох өдрийг тухайн нөхцөлийг засаж, залруулах хүртэл хойшлуулж болно.


- (h) Заалт 10.02 (Хууль зүйн дүгнэлт) хасав.
- (i) Заалт 10.03 (Хүчин төгөлдөр болох өдөр) хасав.
- (j) Заалт 10.04 (Хүчин төгөлдөр болоогүй тохиолдолд цуцлах)-ыг хасав.
- (k) Заалт 10.05 (Төлбөр төлөгдөж дуусгавар болгох)-ыг Заалт 10.02 болгон дахин дугаарлав.
- (l) Заалт 12.01 (Мэдэгдэл ба хүсэлт)-ыг хасаж, дараах утгаар орлуулав:

“Заалт 12.01.Мэдэгдэл ба хүсэлт. Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ болон Батлан даалтын гэрээний дагуу, эсхүл Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ болон Батлан даалтын гэрээнд заасан талуудын бусад гэрээний дагуу хүргүүлэхээр зөвшөөрөгдсөн болоод шаардлагатай аливаа мэдэгдэл, хүсэлтийг бичгээр үйлдэнэ. Тухайн мэдэгдэл, хүсэлтийг хүлээн авагч талын хаяг эсхүл тийнхүү мэдэгдэл, хүсэлт хүргүүлэхэд зориулан албан ёсоор дахин өөрчилж, мэдэгдсэн хаягийг ашиглан биечлэн болон шуудан, факс, цахим шуудангаар илгээгч талаас хүлээн авагч талд хүлээлгэн өгнө.”



Заалт 1.02. Зээлийн журамд тодорхойлсон зарим нэр томъёог энэхүү Зээлийн хэлэлцээрт өөрчлөн тодорхойлоогүй эсвэл тухайн нэг хэсэгт агуулгын хувьд өөр утга илэрхийлээгүй бол тэдгээр нь энэхүү Зээлийн хэлэлцээрт ижил утгаар хэрэглэгдэнэ. Дараах нэмэлт нэр томъёо нь дор дурдсан утгыг илэрхийлнэ. Үүнд:

- (a) “Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллага” гэж зээлийн журамд заасан утгын хүрээнд Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээнд тусгагдсан, тухайн үйл ажиллагааг явуулах үүрэг бүхий байгууллага, агентлагийг;
- (b) “Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ” гэж Зээлдэгч болон АХБ-ны хооронд үндсэндээ энэхүү Хэлэлцээрийн 3-р хуваарьт заасан маягтын дагуу байгуулах захидал гэрээг;
- (c) “Хуваарилалтын хүснэгт” гэж Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээнд заасанчлан Үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгийг тухайн үйл ажиллагааны зардлаар ангилсан, үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгөөс тухайн зардлын ангилалд тус бүрээр зарцуулалтын хувийг харуулсан хүснэгтийг;
- (d) “Зөвлөх үйлчилгээ” гэж Худалдан авах ажиллагааны журам болон Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, Үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх зөвлөх үйлчилгээг;
- (e) “Бараа” гэж Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, Үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх тоног төхөөрөмж, эд материалыг, үүнд тээвэрлэлт, даатгал, суурилуулалт, ашиглалтад оруулах, сургалт, анхны засвар үйлчилгээ зэрэг холбогдох гэрээний дагуух зөвлөх болон зөвлөх бус үйлчилгээ хамаарна;
- (f) “Зээлийн зарцуулалтын гарын авлага” гэж АХБ-наас 2017 онд баталсан зээлийн зарцуулалтын гарын авлага, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг;
- (g) “Зөвлөх бус үйлчилгээ” гэж Худалдан авах ажиллагааны журам болон Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, Үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх Зөвлөхийн бус үйлчилгээг;
- (h) “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө” гэж Худалдан авах ажиллагааны бодлого, Худалдан авах ажиллагааны журам болон АХБ-тай тохиролцсон бусад зохицуулалтын дагуу тухай бүр шинэчлэгдэж, ҮАХГА-д тусгагдсан Үйл ажиллагааны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг;




- (i) “Худалдан авах ажиллагааны бодлого” гэж 2017 онд батлагдсан АХБ-ны Бараа, ажил, зөвлөх болон зөвлөх бус үйлчилгээний худалдан авах ажиллагааны бодлого болон түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг;
- (j) “Худалдан авах ажиллагааны журам” гэж 2017 онд АХБ-ны зээлдэгчдэд зориулан батлагдсан АХБ-ны Бараа, ажил, зөвлөх болон зөвлөх бус үйлчилгээний худалдан авах ажиллагааны журам болон түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг;
- (k) “Дахин санхүүжүүлэх өдөр” гэж (i) дараагийн зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдөр; (ii) Хэрэгжиж буй зээлийн хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлт орсон хувилбар хүчин төгөлдөр болох өдөр; эсвэл (iii) Зээлдэгч болон АХБ-ны хооронд тухай бүр тохиролцон тогтоосон бусад өдрийн аль нэгнээс өмнө тохиох Үйл ажиллагааны дэд зээлийн хугацаа дуусах өдөр;
- (l) “Үйлчилгээ” гэж зөвлөх болон зөвлөх бус үйлчилгээг;
- (m) “Хамгааллын бодлогын баримт бичиг” гэж 2009 онд батлагдсан АХБ-ны хамгааллын бодлогын баримт бичгийг; мөн
- (n) “Ажил” гэж Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаж, Үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх барилгын эсхүл барилга угсралтын ажлыг хэлэх ба үүнд түлхүүр гардуулах эсхүл багц ажлын гэрээний хүрээнд хийгдэх ажил, үйлчилгээг хамруулан тус тус хэлнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Үйл ажиллагааны дэд зээл

Заалт 2.01. АХБ нь тус банкны ердийн хөрөнгийн эх үүсвэрээс Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээнд заасан хэмжээгээр Зээлдэгчид зээл олгохыг зөвшөөрсөн

Заалт 2.02. (a) Үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлтэд заасан валют нь ам.доллар байна.



(b) Үйл ажиллагааны дэд зээл нэг бүрийн үндсэн зээлийн дүн нь долоон сая ам.доллар (7,000,000 ам.доллар)-аас хэтрэхгүй.

Заалт 2.03. (a) Үйл ажиллагааны дэд зээл нэг бүрийн хувьд Зээлдэгч нь Үйл ажиллагааны дэд зээлийн данснаас авч ашигласан бөгөөд зээлийн үндсэн өрийн үлдэгдэл дүн ногдох хүүгийн төлбөрийг хагас жил тутам төлөх бөгөөд хүүгийн хувь нь дараахын нийлбэр байна:

(i) LIBOR;

(ii) Зээлийн журмын Заалт 3.02-т заасан 0.60%-иас Зээлийн журмын Заалт 3.03-т заасан 0.10%-ийг хасаж бодсон үлдэгдэл; мөн

(iii) 0.20%-ийн кредит.

(b) Үйл ажиллагааны дэд зээлийн хүүгийн төлбөрийг Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээнд заасан тодорхой өдөр хагас жил тутамд тооцно.

Заалт 2.04. (a) Зээлдэгч нь Үйл ажиллагааны дэд зээлийн данснаас авч ашигласан Үйл ажиллагааны дэд зээлийн үндсэн төлбөрийг Үйл ажиллагааны дэд зээлийн хугацаа дуусах өдөр хуримтлагдсан хүүгийн хамт бүрэн төлнө.

(b) Үйл ажиллагааны дэд зээлийг дахин санхүүжүүлэх өдөр Дараагийн зээлийн хэлэлцээр эсвэл Хэрэгжиж буй зээлийн хэлэлцээрээр дахин санхүүжүүлсэн тохиолдолд:

(i) Зээлдэгч нь Үйл ажиллагааны дэд зээлийн данснаас татан авсан үйл ажиллагааны дэд зээлийн үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүгийн төлбөрийн хамт Дараагийн зээлийн хэлэлцээр эсхүл Хэрэгжиж буй зээлийн хэлэлцээрийн нөхцөлөөр эргэн төлнө; мөн

(ii) Зээлдэгчийн холбогдох Үйл ажиллагааны дэд зээлийн данснаас зарцуулалт хийх эрх дуусгавар болж, Үйл ажиллагааны дэд зээлийн үлдэгдэл дүнг хүчингүй болгож, Хөтөлбөрийн боломжит дүн дээр нэмж тооцно.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгийг ашиглах

Заалт 3.01. Зээлдэгч нь Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ болон энэхүү ерөнхий нөхцөлийн дагуу үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгийг гагцхүү тухайн Үйл ажиллагааны зардлын санхүүжилтэд зарцуулна.

Заалт 3.02. АХБ-тай өөрөөр тохиролцоогүй тохиолдолд Үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгийг Хуваарилалтын хүснэгтэд заасанчлан зардлын ангилалд хуваарилж, зардлын ангилалд заасан хувийг үндэслэн зарцуулна. Улсын Сангийн яам

АЛБАН БСНЫ ОРЧУУЛГА МЭ

(Гарын үсэг /Signature/ 07.....

2022 оны 01 сарын 12 өдөр

БАНСГААР ХОТ

Заалт 3.03. Үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгийн хуваарилалт, хуваарилалтын хүснэгтэд заасан зарцуулалтын хувийг үл харгалзан,

- (a) Хэрэв аль нэг ангилалд хуваарилсан үйл ажиллагааны дэд зээлийн хэмжээ нь тухайн ангиллын тохиролцсон бүх зардлыг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй гэж үзвэл АХБ Зээлдэгчид мэдэгдэх замаар (i) АХБ-наас өөр шаардлагагүй гэх зардал бүхий ангиллаас шаардагдах хэмжээгээр тэрхүү санхүүжилт дутагдаж буй ангилалд дахин хуваарилж болно; (ii) хэрэв ийнхүү дахин хуваарилалт хийсэн ч тухайн ангилал дахь зардлыг бүрэн санхүүжүүлж чадахгүй тохиолдолд тэдгээрийг бүрэн санхүүжүүлж дуусах хүртэл холбогдох зардлын зарцуулалтын хувийг бууруулна; болон
- (b) Хэрэв аль нэг ангилалд хуваарилсан үйл ажиллагааны дэд зээлийн хэмжээ нь тухайн ангилал дахь бүх зардлаас давсан байвал АХБ Зээлдэгчид мэдэгдэх замаар илүү гарсан дүнг бусад ангилалд дахин хуваарилж болно.

Заалт 3.04. АХБ-тай өөрөөр тохиролцоогүй тохиолдолд Үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгийг Зээлийн зарцуулалтын гарын авлагын дагуу зарцуулна.

Заалт 3.05. (a) Зээлдэгч нь ХБББ-ийн дагуу байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн хувьд А эсвэл В ангилалд хамаарах аливаа үйл ажиллагаа аль ч Үйл ажиллагаанд оруулахгүй байхыг Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан баталгаажуулна.

(b) Зээлдэгч нь Үйл ажиллагааны дэд зээлийн хөрөнгийг ХБББ-ийн Хавсралт 5-д заасан хориглосон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны жагсаалтад орсон аливаа үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглахгүй байхыг баталгаажуулах, эсхүл Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллагаар тийнхүү мөрдүүлнэ.

Заалт 3.06. Зээлдэгч Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан Үйл ажиллагааны дэд зээлийг зөвхөн (a) АХБ-ны одоогийн болон ирээдүйн аливаа түншлэлийн стратегийн хүрээнд АХБ-ны дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн салбар дахь үйл ажиллагаа болон (b) Хөтөлбөрийн хэлэлцээрийн Хуваарь 2-т хавсаргасан Үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлтийн маягтад оруулсан хүснэгтийн "Үйл ажиллагаа" гэсэн мөрөнд тодорхойлсон ангиллын үйл ажиллагааг тус тус дэмжихэд ашиглана. Мөн ямар ч Үйл ажиллагаа нь ХБББ-ийн дагуу байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн хувьд А эсвэл В ангилалд хамаарах аливаа үйл ажиллагааг агуулахгүй байх нөхцөлөөр хангана.

Заалт 3.07. Зээлдэгч нь дараах нөхцөлөөр хангана. Үүнд:

- (a) бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Худалдан авах ажиллагааны бодлого, Худалдан авах ажиллагааны журмын дагуу явуулах;
- (b) Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах, сонгон шалгаруулах арга, тендерийн баримт бичгийн төрөл, АХБ-ны хяналтын шаардлага зэрэг нарийвчилсан зохицуулалтыг үндэслэн худалдан авна. Зээлдэгч нь Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан

Харгалсан үеийн үндэслэл /Signature/ 07
2022.01.12
ХТДН-2022-01 ХОТ


нарийвчилсан зохицуулалтыг зөвхөн АХБ-тай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр өөрчлөх боломжтой бөгөөд эдгээр өөрчлөлтийг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд шинэчлэн тусгана; мөн

- (c) (i) Худалдан авсан бүх бараа, ажил, хүлээн авсан үйлчилгээ (тус тусад нь худалдаж авсан эсвэл бусад бараа, үйлчилгээнд дагалдуулан авсан бүх компьютерын техник хангамж, програм хангамж, системийг оруулаад) нь үйлдвэрлэлийн өмч, оюуны өмчийн эрхийг зөрчөөгүй, эсвэл гуравдагч этгээдийн хууль ёсны эрхийг зөрчөөгүй; мөн (ii) бараа, ажил, үйлчилгээ худалдан авах бүх гэрээнд энэхүү дэд зүйлд дурдсан асуудлаар гэрээлэгч, ханган нийлүүлэгч, зөвлөх, үйлчилгээ үзүүлэгчээс зохих мэдэгдэл, баталгаа, мөн шаардлагатай бол хохирол нөхөн төлүүлэх заалт тусгасан байна.

Заалт 3.08. Үйл ажиллагааны дэд зээлийн данснаас бараа, ажил, үйлчилгээнд зарцуулахдаа зөвхөн дараах зардлыг санхүүжүүлэх боломжтой. Үүнд:

- (a) Худалдан авалтын зохих эх үүсвэр хэмээн АХБ-ны тухай бүр тодорхойлсон АХБ-ны гишүүн орнуудад үйлдвэрлэсэн болон тэдгээрээс нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээ; мөн
- (b) АХБ-ны тухай бүр бусад шаардлагад хангасан хэмээн зарласан бараа, ажил, үйлчилгээ.

Заалт 3.09. Зээлдэгч нь АХБ-ны төлөөлөгчдөд Үйл ажиллагаа, бараа, ажил болон холбогдох бүртгэл, баримт бичгийг шалгах боломжоор хангана.



ХӨТӨЛБӨРИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХУВААРЬ 2

Үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлтийн хэлбэр

Огноо

Азийн Хөгжлийн Банк
[]-ны газарт
АХБ өргөн чөлөө 6
Мандалуйонг хот
1550 метро Манила
Филиппин


Хэнд: [], []

Тухай: Жижиг зардлыг санхүүжүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагааны дэд зээл (энгийн үйл ажиллагаа)

Эрхэм [Ноён] [хатагтай],

- Бид Зээлдэгч болон АХБ хоорондын [огноо оруулах]-ны Хөтөлбөрийн хэлэлцээр (ердийн үйл ажиллагаа) ("Хөтөлбөрийн хэлэлцээр" гэх)-т үндэслэн энэхүү жижиг зардлын санхүүжилтийн Үйл ажиллагааны дэд зээл ("Үйл ажиллагааны дэд зээл") авах хүсэлт ("Үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлт") гаргаж байна.
- Бид дараах нөхцөлөөр Үйл ажиллагааны дэд зээл авахыг хүсэж байна.


Үйл ажиллагаа	<p>Үйл ажиллагаа нь доор дурдсан АХБ-ны санхүүжилттэй төслийн төсөл[үүд]-ийн [бэлтгэл] [хэрэгжилт] [дуусгасны дараах ажиллагаа]-г дэмжих юм:</p> <ul style="list-style-type: none">(a) ТЭЗҮ, үүнд урьдчилсан инженерийн дизайн; зардлын тооцоо; техникийн, санхүүгийн, эдийн засаг, нийгэм, эдийн засгийн шинжилгээ; байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ; мөн чадавхыг бэхжүүлэх;(b) инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, үүнд техникийн нөхцөл, зураг төсөл, зардлын нарийвчилсан тооцоо, болон Дараагийн эсхүл хэрэгжиж буй төсөл(үүд)-ийн байгаль орчин, нийгмийн хамгааллын төлөвлөлтийн баримт бичиг;(c) Урьдчилсан худалдан авалтын арга хэмжээ, үүнд Дараагийн төсөл(үүд)-ийн тендерийн баримт бичиг болон гэрээ байгуулах хүртэл тендерийн үйл явцыг дэмжих;
---------------	--



	<p>(d) (i) туршилт тест, (ii) нөхөн сэргээлтийн ажил, (iii) гамшгийн дараах сэргээн босголтын ажил, (iv) ашиглалт, засвар үйлчилгээний гэрээ зэрэг АХБ-ны санхүүжилттэй төслүүдтэй холбоотой буюу тэдгээрийг дэмжих жижиг тоног төхөөрөмж, ажил, үйлчилгээ;</p> <p>(e) АХБ-ны нөхөн олгогдох техникийн туслалцаа болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлцлийн зөвлөх үйлчилгээний төлбөр; [болон][эсвэл]</p> <p>(f) Үйл ажиллагааны дэд зээлийн орлогын ашиглалтад хөндлөнгийн аудит.]</p> <p>Энэхүү үйл ажиллагааг [] гэхэд хэрэгжүүлж дуусгана.</p>
[Дараагийн төсөл(үүд)][хэрэгжиж буй төсөл(үүд)][хэрэгжилтийн дараах дэмжлэг]	[]
Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллага	[] эсхүл АХБ-ны хүлээн зөвшөөрсөн түүний эрх үүрэг залгамжлагч
Үйл ажиллагааны дэд зээлийн дүн	[ам.долларын дүн оруулах] (ам.доллар)
Үйл ажиллагааны дэд зээлийн хугацаа дуусах өдөр	[]
Хүү	Үйл ажиллагааны дэд зээлүүдэд хамаарах Ерөнхий нөхцөл 2.02 заалтад болоод тухайн Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээний заалтуудад тусгасанчлан
Хүү хуримтлагдах өдөр	[] ба []
Хүү төлөх өдөр	Үйл ажиллагааны дэд зээлийн хугацаа дуусах өдөр
Үйл ажиллагааны дэд зээл хаах өдөр	[]
Хуваарилалтын хүснэгт	Энэхүү үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлтийн хавсралтад заасан бөгөөд АХБ-наас Зээлдэгчид мэдэгдэн өөрчилж болно.

3. Хөтөлбөрийн гэрээнд тусгагдсан, ЖЗСХ-ийн суурь болсон ерөнхий ойлголт, хүлээлттэй нийцсэн байдлаар хэвийн явагдаж байгааг бид үүгээр баталж байна.


4. Энэхүү Үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлтийг Хөтөлбөрийн хэлэлцээрийн 3.01 заалтад заасны дагуу АХБ хянаж, батлах ёстойг бид хүлээн зөвшөөрч байна.



Хүндэтгэсэн

[Нэр, албан тушаал] ¹

¹ Зээлдэгчийн алба ёсны төлөөлөгч байна.



Хуваарилалтын хүснэгт²

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭД ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙН ХУВААРИЛАЛТ БА ЗАРЦУУЛАЛТ				
Дугаар	Зориулалт.	АХБ-ны санхүүжүүлэх хөрөнгийн нийт хэмжээ [зээлийн валют оруулах]		Үйл ажиллагааны дэд зээлийн данснаас гарах санхүүжилтийн хувь
		Ангилал	Дэд ангилал	
1	Ажил [**]			
1A				Нийт нэхэмжилсэн зардлын _____%[*]
1B				Нийт нэхэмжилсэн зардлын _____%
2	Бараа			
2A				Нийт нэхэмжилсэн зардлын _____%
2B				Нийт нэхэмжилсэн зардлын _____%
3	Зөвлөх үйлчилгээ			Нийт нэхэмжилсэн зардлын _____%
4	Хуваарилагдаагүй			
	НИЙТ			

[* Зээлдэгчийн нутаг дэвсгэрт ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татварыг оруулаагүй.]


[**Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээнд заасан буцаан зарцуулалтын нөхцөл үйлчилнэ.]

² Хэдий түгээмэл бус ч үйл ажиллагааны онцлог шалтгааны улмаас тохиромжтой эсвэл шаардлагатай гэвэл ангиллыг дэд ангилалд хувааж болно (зөвхөн дээрх 1 болон 2-р ангилалд жишээ болгосон); гэхдээ ямар ч дэд ангиллыг дахин хувааж болохгүй.

Дотоодын татварыг АХБ-наас санхүүжүүлдэггүй бөгөөд зарцуулалтын хувийг татвараас хассан байдлаар харуулсан бол зардлын холбогдох ангиллын ард "***" гэж тэмдэглэж, Хүснэгтийн доор "**Зээлдэгчийн нутаг дэвсгэрт ногдуулах татвар, хураамжийг оруулаагүй." Хэмээн оруулна. Үйл ажиллагаанаас хамааран өөрчлөлт оруулж болзошгүй тул хуульч нь СТЛ-тэй зөвлөлдөх хэрэгтэй. Хуульч мөн ОМ J6 болон АХБ-ны санхүүжилт: Шинэ хандлага (2006) зардлын хуваах, эрх олгох зардлын талаарх ажилтнуудын зааварчилгааг унших ёстой.

Хэрэв зардлын ангилалд зарцуулалт хийхэд нөхцөл тавигдах бөгөөд тус тусад нь ангилсан бол зардлын холбогдох ангиллын ард "***" гэж бичээд Хүснэгтийн доор нь "*** Үйл ажиллагааны дэд зээлийн хэлэлцээрт заасан зарцуулалтын нөхцөл үйлчилнэ" гэж оруулна. Үйл ажиллагаанаас хамааран өөрчлөлтүүд оруулж болзошгүй тул хуульч нь СТЛ-тэй зөвлөлдөх хэрэгтэй.

Үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлтийг гаргах үед хавсралтыг бөглөхөд шаардлагатай мэдээлэл байхгүй байхаас бусад тохиолдолд энэ хавсралтыг бүх үйл ажиллагааны дэд зээлийн хувьд бөглөх ёстой.



ХӨТӨЛБӨРИЙН ХЭЛЭЛЦЭЭР ХУВААРЬ 3
Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээний хэлбэр

Огноо

[]

[]

Улс

Тухай: Жижиг зардлыг санхүүжүүлэх үйл ажиллагааны дэд зээл
 Зээлийн дугаар: SEFF [____]-MON(Энгийн үйл ажиллагаа)


Эрхэм [Ноён] [хатагтай],

1. Азийн Хөгжлийн Банк (“АХБ”) нь Зээлдэгчид жижиг зардлын санхүүжилтийн үйл ажиллагааны дэд зээл (“Үйл ажиллагааны дэд зээл” гэх) авах тухай [____] (“Зээлдэгч”)-ийн хүсэлт (“Үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлт” гэх) хүсэлтийг доор дурдсан үйл ажиллагаа болон хүснэгтэд заасан нөхцөлөөр олгохоор [огноо оруулах]-нд баталсныг дуулгахад таатай байна.
2. Үйл ажиллагааны дэд зээлийг Зээлдэгч болох АХБ-ны хоорондын [огноо оруулах]-ийн Хөтөлбөрийн хэлэлцээр (энгийн үйл ажиллагаа)-ийн дагуу олгох юм. Зээлдэгч болон АХБ энэхүү үйл ажиллагааг энэхүү захидал гэрээ (“Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ”)-нд заасан нөхцөл, болзлын дагуу санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг үүгээр зөвшөөрч байна.
3. Хөтөлбөрийн хэлэлцээрийн Хуваарь 1-т заасан ерөнхий нөхцөл, болзол (“Ерөнхий нөхцөл”) нь үйл ажиллагааны дэд зээлийн гэрээнд бүрэн тусгагдсантай адил хүчинтэй төгөлдөр үйлчилнэ. Тухайн хэсэгт агуулгын хувьд өөрөөр заагаагүй бол энэхүү Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээнд том үсгээр бичсэн нэр томъёо нь Ерөнхий нөхцөл заасан ижил утгыг илэрхийлнэ.

<p>Үйл ажиллагаа</p>	<p>Үйл ажиллагаа нь доор дурдсан АХБ-ны санхүүжилттэй төслийн төсөл[үүд]-ийн [бэлтгэл] [хэрэгжилт] [дуусгасны дараах ажиллагаа]-г дэмжих юм:</p> <p>(a) [ТЭЗҮ бэлтгэх, үүнд урьдчилсан инженерийн дизайн; зардлын тооцоо; техникийн, санхүүгийн, эдийн засаг, нийгэм, эдийн засгийн шинжилгээ; байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ; мөн чадавхыг бэхжүүлэх;</p> <p>(b) инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, үүнд техникийн нөхцөл, зураг төсөл, зардлын нарийвчилсан тооцоо, болон Дараагийн эсхүл хэрэгжиж буй төсөл(үүд)-ийн байгаль орчин, нийгмийн хамгааллын төлөвлөлтийн баримт бичиг;</p> <p>(c) урьдчилсан худалдан авалтын арга хэмжээ, үүнд Дараагийн төсөл(үүд)-ийн тендерийн баримт бичиг болон гэрээ байгуулах хүртэл тендерийн үйл явцыг дэмжих;</p>
----------------------	--

2022 оны 01 сарын 12 өг
 Дугаар хөтөлбөр /Signature/ 01
 Ministry of Finance of Mongolia
 2022

	<p>(d) (i) туршилт тест, (ii) нөхөн сэргээлтийн ажил, (iii) гамшгийн дараах сэргээн босголтын ажил, (iv) ашиглалт, засвар үйлчилгээний гэрээ зэрэг АХБ-ны санхүүжилттэй төслүүдтэй холбоотой буюу тэдгээрийг дэмжих жижиг тоног төхөөрөмж, ажил, үйлчилгээ;</p> <p>(e) АХБ-ны нөхөн олгогдох техникийн туслалцаа болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлцлийн зөвлөх үйлчилгээний төлбөр; [болон][эсвэл]</p> <p>(f) Үйл ажиллагааны дэд зээлийн орлогын ашиглалтад хөндлөнгийн аудит.]</p> <p>Энэхүү үйл ажиллагааг [] гэхэд хэрэгжүүлж дуусгана.</p>
[Дараагийн төсөл(үүд)][хэрэгжиж буй төсөл(үүд)][хэрэгжилтийн дараах дэмжлэг]	[]
Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллага	[] эсхүл АХБ-ны хүлээн зөвшөөрсөн түүний эрх үүрэг залгамжлагч
Үйл ажиллагааны дэд зээлийн дүн	[ам.долларын дүн оруулах] (ам.доллар)
Үйл ажиллагааны дэд зээлийн хугацаа дуусах өдөр	[]
Хүү	Дараахын нийлбэр: (a) LIBOR; (b)Зээлийн журмын Заалт 3.02-т заасан 0.60%-иас Зээлийн журмын Заалт 3.03-т заасан 0.10%-ийг хасаж бодсон үлдэгдэл; мөн (c)0.20%-ийн кредит
Хүү хуримтлагдах өдөр	[] ба []
Хүү төлөх өдөр	Үйл ажиллагааны дэд зээлийн хугацаа дуусах өдөр
Хамгааллын нөхцөл	[Хамгаалалтай холбоотой бусад заалтыг оруулах]
Үйл ажиллагааны дэд зээл хаах өдөр	[]
Хуваарилалтын хүснэгт	Хавсралт
Зээлдэгчийн төлөөлөгч	Зээлийн журмын 12.02 заалтын зорилгоор Зээлдэгч талын төлөөлөгч нь Зээлдэгчийн Сангийн сайд болно.
Хаяг	<p>Зээлийн журмын 12.01 заалтын зорилгоор дараах хаягийг ашиглана:</p> <p><u>Зээлдэгчийн хувьд</u></p> <p>Сангийн яам С.Данзангийн гудамж 5/1 Засгийн газрын 2-р байр Улаанбаатар - 15160 Монгол Улс</p> <p>Факс: (976-11) 320-247</p>



	<p><u>АХБ-ны хувьд</u></p> <p>Азийн Хөгжлийн Банк Азийн Хөгжлийн Банкны өргөн чөлөө 6 Мандалуйонг хот 1550 Метро Манила Филиппин Улс</p> <p>Факс: (632) 8636-2444 (632) 8636-2302.</p>
--	---

4. Энэхүү Хэлэлцээрийн бусад заалтыг үл харгалзан [нөхцөл хангах тохиолдлыг тодорхой бичих] хүртэлх []-д зориулж Үйл ажиллагааны дэд зээлийн данснаас зарцуулалт хийхгүй

5. АХБ-ны Мэдээллийн хүртээмжийн бодлого ("МХБ")-д мэдээллийг нийтэд ил болгож, солилцох тухай заасны дагуу энэхүү Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээг хоёр тал гарын үсэг зурсны дараа АХБ-ны цахим хуудсанд нийтлэх болно. Энэхүү Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ нь МХБ-д заасны дагуу чөлөөлөгдөх нөхцөлд хамаарах эмзэг, нууц шинж чанартай аливаа мэдээлэл, дата агуулж байгааг АХБ-нд мэдэгдсэн тохиолдолд эдгээр мэдээллийг засварласны дараа ил болгоно.

6. Зээлдэгч өөрийн эрх бүхий төлөөлөгчөөр энэхүү Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээний хоёр эх хувийн доор заасан хэсэгт гарын үсэг зурж, улмаар энэхүү Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээ нөхцөл, болзол, мөн Хөтөлбөрийн хэлэлцээрийн тухай []-ны өдрийн хууль зүйн дүгнэлт [хүчинтэй байх гэх мэт]-ийг зөвшөөрч байгаагаа баталгаажуулахыг бид ийнхүү хүсэмжилж байна. АХБ-ны төлөөлөгчийн гарын үсэг зурсан нэг эх хувийг дотоодын хэрэгцээнд үлдээж, үлдэж буй гарын үсэгтэй эх хувийг АХБ-инд буцаан ирүүлнэ үү.


Хүндэтгэсэн

[Нэр, албан тушаал] ¹

Зээлдэгч нь үүгээр Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээний нөхцөл, болзлыг зөвшөөрч байна.

Монгол Улсыг төлөөлж:

Нэр:
Албан тушаал:
Огноо:




Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллага нь энэхүү Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээнд заасан бүх үүргийг Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллагад хамаарах хэмжээнд биелүүлэхийг зөвшөөрч байна.

Үйл ажиллагаа гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж:

Нэр:
Албан тушаал:
Огноо:

Хавсралт: ҮАХГ



Хуваарилалтын хүснэгт³

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭД ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙН ХУВААРИЛАЛТ БА ЗАРЦУУЛАЛТ				
Дугаар	Зориулалт.	АХБ-ны санхүүжүүлэх хөрөнгийн нийт хэмжээ [зээлийн валют оруулах]		Үйл ажиллагааны дэд зээлийн данснаас гарах санхүүжилтийн хувь
		Ангилал	Дэд ангилал	
1	Ажил [**]			
1А				Нийт нэхэмжилсэн зардлын ____%[*]
1Б				Нийт нэхэмжилсэн зардлын ____%
2	Бараа			
2А				Нийт нэхэмжилсэн зардлын ____%
2Б				Нийт нэхэмжилсэн зардлын ____%
3	Зөвлөх үйлчилгээ			Нийт нэхэмжилсэн зардлын ____%
4	Хуваарилагдаагүй			
	НИЙТ			

[* Зээлдэгчийн нутаг дэвсгэрт ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татварыг оруулаагүй.]

[**Үйл ажиллагааны дэд зээлийн гэрээнд заасан буцаан зарцуулалтын нөхцөл үйлчилнэ.]

³ Хэдий түгээмэл бус ч үйл ажиллагааны онцлог шалтгааны улмаас тохиромжтой эсвэл шаардлагатай гэвэл ангиллыг дэд ангилалд хувааж болно (зөвхөн дээрх 1 болон 2-р ангилалд жишээ болгосон); гэхдээ ямар ч дэд ангиллыг дахин хувааж болохгүй.

Дотоодын татварыг АХБ-наас санхүүжүүлдэггүй бөгөөд зарцуулалтын хувийг татвараас хассан байдлаар харуулсан бол зардлын холбогдох ангиллын ард “*” гэж тэмдэглэж, Хүснэгтийн доор “Зээлдэгчийн нутаг дэвсгэрт ногдуулах татвар, хураамжийг оруулаагүй.” хэмээн оруулна. Үйл ажиллагаанаас хамааран өөрчлөлт оруулж болзошгүй тул хуульч нь STL-тэй зөвлөлдөх хэрэгтэй. Хуульч мөн OM J6 болон АХБ-ны санхүүжилт: Шинэ хандлага (2006) зардлын хуваах, эрх олгох зардлын талаарх ажилтнуудын зааварчилгааг унших ёстой.

Хэрэв зардлын ангилалд зарцуулалт хийхэд нөхцөл тавигдах бөгөөд тус тусад нь ангилсан бол зардлын холбогдох ангиллын ард “***” гэж бичээд Хүснэгтийн доор нь “** Үйл ажиллагааны дэд зээлийн хэлэлцээрт заасан зарцуулалтын нөхцөл үйлчилнэ” гэж оруулна. Үйл ажиллагаанаас хамааран өөрчлөлтүүд оруулж болзошгүй тул хуульч нь STL-тэй зөвлөлдөх хэрэгтэй.

Үйл ажиллагааны дэд зээлийн хүсэлтийг гаргах үед хавсралтыг бөглөхөд шаардлагатай мэдээлэл байхгүй байхаас бусад тохиолдолд энэ хавсралтыг бүх үйл ажиллагааны дэд зээлийн хувьд бөглөх ёстой.

